



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2009 оны 4 дүгээр сар

Компанийн засаглалын хөгжлийн төв байгуулагдав

2009 оны 4 дүгээр сарын 9-нд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Санхүү, эдийн засгийн дээд сургууль (СЭЗДС) хамтран Монголын Компанийн засаглалын хоёрдугаар чуулганыг зохион байгуулж, Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн төвийг (МКЗХТ) байгуулав. Уг арга хэмжээн дээр МКЗХТ-ийн үзэл баримтлалын талаар презентаци тавьж, эхний бизнес төлөвлөгөөг танилцууллаа.

2008 оны 9 дүгээр сард монголын компаниудын дунд компанийн засаглалын талаар уг төслөөс хийсэн дүн шинжилгээний үр дүнд МКЗХТ байгуулагдсан болно. Шинжилгээний ажлын дүнг 2008 оны 10 дугаар сарын 9-нд болсон МКЗ-ын анхдугаар чуулганаар танилцуулж, МКЗХТ байгуулах тухай тогтоолд оролцогч талууд гарын үсэг зурав. Энэ оны 3 дугаар сарын 6-нд төрийн бус байгууллага болох МКЗХТ-ийг байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт СЗХ, СЭЗДС гарын үсэг зурж, дараах гол гурван үйл ажиллагаанд анхаарлаа чиглүүлэхээр тохиролцов: компанийн ТУЗ-ын гишүүд, захирлуудад зориулсан сургалт зохион байгуулах, компанийн засаглалын талаар судалгаа хийж, стандарт тогтоох, компанийн засаглалын нөлөөллийн талаар олон нийтэд таниулан ойлгуулах зэрэг багтана. Тус төвийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, гишүүнчлэлийн тоог нэмэгдүүлэх зэрэг зохион байгуулалтын хөгжлийн явцад нь уг төслөөс цаашид туслалцаа дэмжлэг үргэлжлүүлэн үзүүлсээр байх болно.

буй монголын янз бүрийн байгууллага, хувь хүмүүсийн хүчин чармайлтыг нэгтгэх талбар болж чадна гэж найдаж байна.

Монголын бизнес эрхлэгчдэд дотооддоо болон олон улсад илүү үр ашигтайгаар өрсөлдөх бизнесийн орчин бүрдүүлэхэд төрийн бодлого боловсруулагчид, санал гаргагчид болон олон нийтийн үүрэг ролийг хөхүүлэн дэмжихэд энэхүү төв нь чухал ач холбогдолтой.



МКЗХТ нь гишүүнчлэлд тулгуурласан ТББ бөгөөд гишүүнчлэлийн хураамж хурааж, төлбөртэй сургалт, семинар явуулах замаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэхийг эрхэмлэнэ. Энэ оны 3 дугаар сард болсон үүсгэн байгуулагчдын хурлаар монголын бие даасан бизнес эрхлэгчид мөн СЗХ, СЭЗДС-ийн төлөөлөгчдөөс бүрдсэн нийт 9 хүн тус төвийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогджээ. Компанийн шилдэг засаглалын туршлагаар МКЗХТ-ийн гүйцэтгэх захирлыг өрсөлдөөнт шалгаруулалтаар ТУЗ сонгон шалгаруулах ажлыг эхлээд байгаа аж. МКЗХТ-ийн бизнес төлөвлөгөө, дүрмийг боловсруулах ажилд ТУЗ-ийн үүсгэн байгуулагчдад уг төслөөс туслалцаа үзүүлсээр байгаа юм.

Эрчим хүчний зах зээлийн загварын асуудлаар сургалт-семинар боллоо

Энэ оны 4 дүгээр сарын 2-нд ЭХЗГ, ЭЗБШӨЧ төслөөс хамтран ЭБЭХЯ, ТӨХ-ны удирдах ажилтнуудад зориулан эрчим хүчний шинэ зах зээл, хоёр талт гэрээний асуудлаар сургалт-семинар зохион байгууллаа. Уг сургалт нь ЭХЗГ, ЭЗБШӨЧ төслөөс сүүлийн хэдэн сар Төвийн эрчим хүчний системийн (ТЭХС) оролцогч талуудад зохион байгуулж буй цуврал сургалт-семинарын нэг хэсэг юм.



МКЗХТөв нь компанийн захирал, гүйцэтгэх албан тушаалтнуудад компанийн засаглалын талаар зохих мэдлэг, ур чадварыг олгож, компанийн засаглалыг хөхүүлэн дэмжиж

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

Зах зээлийн загварын хоёр талт гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуултыг оролцогчид тавьж, санал бодлоо солилцсон болно. Ихэнх асуулт, саналууд тулгарч болзошгүй техник, санхүүгийн бэрхшээлтэй холбоотой байснаас гадна уг салбарт өөрчлөлт шинэчлэл зайлшгүй хийе гэсэн улс төрийн хүсэл зориг шаардлагатай гэсэн асуудалд чиглэгдэж байв.

Хэрэглэгчийн тарифыг зардлаа нөхөх хэмжээнд хүртэл аажмаар нэмэгдүүлэх Тарифын шинэчлэлийн төлөвлөгөөг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхгүйгээр шинэ зах зээл амжилтанд хүрэхгүйгээс гадна хувийн хөрөнгө оруулагчдыг татах боломж бүрдэхгүй гэдэг дээр сургалтанд оролцогчид санал нэгтэй байлаа.



ТХЭС-ийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид, ЭХЗГ-ын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсгийнхэн Зах зээлийн дүрмийн хоёр дахь төслийг хянан үзэж, ТЭХС-ийн бүх ТЗЭ-ийн саналыг авсныг дараа Зах зээлийн дүрмийг 5 дугаар сарын сүүлээр эцэслэн шийдвэрлэхээр тохиролцов.

Сэтгүүлчдэд зориулан татварын асуудлаар сургалт зохиолоо

ЭЗБШӨЧ төслөөс Татварын Ерөнхий Газар болон Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран 4 дүгээр сарын 8-нд "Татварын шинэчлэлийн асуудал ба татвар бүрдүүлэлтэд эдийн засгийн хямралын үзүүлж буй нөлөө" сэдэвт сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулав.



Сэтгүүлчдийн татварын тухай мэдлэг, МУ-ын татварын нийт орлогод дэлхийн эдийн засгийн өнөөгийн хямралын үзүүлж буй сөрөг нөлөөний талаархи мэдээллийг нь дээшлүүлэх зорилготой уг сургалтанд 11 сонин, 9 телевиз, 2 радио, 3 сэтгүүл болон МОНЦАМЭ агентлаг зэрэг хэвлэл мэдээллийн

байгууллагаас нийт 27 сурвалжлагч оролцлоо. Түүнчлэн сургалтын үеэр 2006 онд УИХ-аар баталж, 2007 оны 1 дүгээр сараас мөрдөж эхэлсэн татварын шинэчлэл нийт татварын орлого бүрдүүлэлтэнд ямар үр нөлөө үзүүлсэн талаар ТЕГ-аас тоо баримттай ярьж танилцуулсан байна.

ТЕГ-ын Татварын удирдлага, хамтын ажиллагааны хэлтсийн байцаагч Б.Бадрал "2007 оны татварын шинэчлэл хийх шаардлага ба өнөөгийн татварын орчин" сэдвээр яриа хийж, татварын ерөнхий зарчим, түүний нийгэмд хүлээх үүрэг, роль, татварын объект, субъект, татварын хэмжээ, ангиллын талаар дэлгэрэнгүй тайлбарлав. Мөн шилжилтийн үеийн чөлөөт зах зээл болон хувийн хэвшлийн хөгжилд саад тотгор болж байсан өмнөх татварын хуулиудын тодорхой бус заалтуудыг 2006 онд татварын шинэчлэл хийж өөрчилсөн тухай ярилаа.

ЭЗБШӨЧ төслийн эдийн засагч, шинжээч Б.Гүндалай, С.Отгонбаяр нар "Татварын шинэчлэлийн үр дүн: Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), Аж ахуйн нэгжийн ашиг орлогын албан татвар (ААНАОАТ), Хувь хүний ашиг орлогын албан татвар (ХХАОТ)" –ын талаар хийсэн судлагааны дүнг дэлгэрэнгүй танилцуулж, татварын суурийг өргөтгөж, татвар хураалтыг нэмэгдүүлэх зорилготой татварын шинэчлэлийн ерөнхий зорилтууд хэрэгжсэн тухай урьдчилсан дүгнэлт гарсаныг мэдээллээ. Татварын шинэ болон өмнөх хуулиудыг харьцуулахад татварын өнөөгийн орчин хувийн хэвшлийнхэнд илүү таатай болсныг судлагааны дүн харуулж байгаа юм.

ТЕГ-ын Татвар хураалт, үйлчилгээний хэлтсийн дарга О.Цогт "Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар ба татварын нийт орлогод үзүүлж буй үр нөлөө" сэдэвт яриа хийж, ЗБҮӨАТ –ын хуулийг мэргэжилтнүүдэд хянуулалгүйгээр гаргасан нь маргаантай хууль болох шалтгаан болсон тухай хийгээд уг хуулийн улсын төсөв ба гадаадын хөрөнгө оруулалтад үзүүлж буй нөлөөллийн асуудлыг хөндөж санал солилцов.



ТЕГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга О.Тэнгис "Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад учирч буй бэрхшээлүүд ба түүнийг хэвлэлээр хүргэх зарим санаа"-ны талаар асуудал дэвшүүлж, татвар төлөхөөс зайлсхийж буй жишээ, татвар бүрдүүлэлтэд тулгарч буй хүндрэл, эдгээр асуудалтай холбоотой шүүхийн шийдвэрүүдийн талаар онцлон яриу.

Сургалтын үдээс хойшхи хөтөлбөрийн дагуу О.Цогт, О.Тэнгис нар бүлгийн ажилд оролцож, татварын бэрхшээлтэй асуудлуудыг хэрхэн үр дүнтэй, үнэн зөв сурвалжилж, мэдээлэх талаар сэтгүүлчдэд зөвлөгөө өгч, тэдний тавьсан асуултад дэлгэрэнгүй хариуллаа. Түүнчлэн, татвар хураалтанд учирч буй бэрхшээлтэй асуудлуудаар чанартай нийтлэл гаргахад туслалцаа үзүүлэхэд бэлэн буйгаа илэрхийлсэн байна.

Сургалтанд оролцогсод бүлгээр ажилласан нь татварын талаархи мэдлэгийг нь дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой

болсныг тэмдэглээд, илтгэгчид асуудлыг баримт сайтай, сонирхолтой байдлаар хөндөж танилцуулсныг онцолжээ. "Ийм сургалт зохион байгуулсанд талархал илэрхийлье. Уг сургалтаар нийгэм болон нийгмийн сайн сайханд татвар ямар чухал үүрэгтэйг мэдэж авлаа" гэж сурвалжлагчид үнэлгээний хуудсандаа бичсэн байна.

Зээлийн мэдээллийн төв ХХК семинар зохион байгуулав

Зээлийн мэдээллийн төв ХХК-ийг (ЗМТ) улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш таван өдрийн дараа буюу энэ 4 дүгээр сарын 6-ны өдөр ЭЗБШӨЧ төсөл, Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Монголын Банкуудын холбооны (МБХ) дэмжлэгтэйгээр УИХ-ын гишүүдэд зориулсан нэг өдрийн семинар зохион байгуулав. Энэхүү семинарын гол зорилго нь дэлхий нийтийн хэмжээнд улс орнуудад ажиллаж буй зээлийн мэдээллийн сангуудын (ЗМС) үйл ажиллагааны талаар танилцуулж, Монгол улсад энэ төрлийн үйл ажиллагааг явуулахад зохих эрх зүйн орчин шаардлагатай байгаа тухай мэдээллээр хангахад оршиж байв.



Монголбанк, ЗМТ-тэй холбоотой байгууллагууд, дэмжигчдээс гадна Ази, Зүүн Европ, Өмнөд Африк, Америкийн зээлийн мэдээллээр хангадаг хувийн хэвшлийн тэргүүлэх компаниудын төлөөлөгчид илтгэл тавьсан уг семинарт ЗМТ-ийн оролцогч талууд, хэвлэл мэдээллийн хэрэгслийг төлөөлсөн 54 хүн оролцлоо. Семинарыг нээж Монголбанкны дэд ерөнхийлөгч Б. Энххуяг үг хэлсэн бөгөөд тэрбээр төв банкны зүгээс ЗМТ-ийн санаачлагыг дэмжиж буйгаа илэрхийлсэн юм. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн бөгөөд орлогч дарга Д. Дүгэржав, ЗМТ-ийн ТУЗ-ийн дарга, МБХ-ны дэд ерөнхийлөгч М. Болд, ОУСК-ийн Монголыг хариуцсан зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга М. Фишель нарын өндөр албан тушаалын хүмүүс нээлтэд оролцож үг хэллээ.

ОУСК-ийн ЗМС-гийн тэргүүлэх зөвлөх Колин Раймонд ЗМС-гийн олон улсын чиг хандлага, шилдэг туршлагын талаар, мөн ОУСК-ийн Санхүүгийн тэргүүлэх мэргэжилтэн Тони Литгои зээлийн мэдээллийн сангийн тайлагналын эрх зүйн болон зохицуулалтын орчны дэлхий нийтийн чиг хандлагын талаар оролцогчдод илтгэл тавилаа. Семинарын үдээс өмнөх хэсэгт Монгол Шуудан банкны дэд захирал, ЗМТ-ийн хуулийн ажлын хэсгийн ахлагч З. Нарантуяа хувийн хэвшлийн ЗМС-гийн хөгжлийн өнөөгийн байдал, мөн Монгол улсад үйл ажиллагаа явуулах хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн сангуудын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн болон зохицуулалтын санал болгож буй хүрээг танилцуулав.

Семинарын үдээс хойшхи хэсэгт Сингапур улсын Зээлийн мэдээллийн сангийн гүйцэтгэх захирал Вильям Лим Сингапур улсад хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн сан байгуулсан туршлагын талаар, шилжилтийн орнуудын зээлийн мэдээллийн сангаар мэргэшсэн Итали улсад төвтэй CRIF

байгууллагын гүйцэтгэх захирал Карло Герарди Итали болон Зүүн Европын улс орнуудын туршлагын талаар тус тус илтгэл тавьсан юм. Мөн AP Experian компанийн захирал Деннис Мартин зээлийн мэдээллийн сангийн бүтээгдэхүүнүүдийн талаар илтгэл тавьсан бөгөөд эдгээрийн дийлэнх нь Монгол улсын ЗМТ үйл ажиллагаагаа явуулж эхэлмэгц, улмаар үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд үйлчилгээ үзүүлж болохуйц бүтээгдэхүүнүүд байлаа. Голомт банкны Эрсдэлийн газрын захирал М. Чингүүн Монголын зах зээлд зээлийг үнэлэхтэй холбоотойгоор тулгарч буй бэрхшээлүүдийн талаар танилцуулж, эдгээр хүндрэлийг шийдвэрлэхэд хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байгаа тухай онцоллоо. CompuScan компанийн Маркетингийн хэлтсийн захирал Фрэнк Лениса бичил санхүүгийн орчинд зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээг ашиглах нь сэдвээр мөн илтгэл тавилаа.

Семинарын төгсгөлд Монгол улсын нөхцөл байдалд зээлийн мэдээллийн сан байгуулахын ач холбогдол, хүндрэлтэй асуудлуудын талаар ажил хэрэгч ярилцлага боллоо. УИХ-ын гишүүн, Эдийн засгийн бодлогын байнгын хорооны дарга Ц. Баярсайхан семинарт мөн оролцсон бөгөөд ЗМС-гийн үйл ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлэхэд шаардагдах багц хуулиудыг дэмжихээ илэрхийлсэн юм. ЭЗБШӨЧ төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн төслийг УИХ-ын 2009 оны хаврын чуулганд өргөн барихаар бэлтгэж байна.

Сэтгүүлчид татвар хураалтад хямрал хэрхэн нөлөөлж буй талаар бодит мэдээлэл авах зорилгоор Эрдэнэтэд зочиллоо

Татвартай холбоотой асуудлаар 2009 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр болсон сургалтын үеэр гарсан санал хүсэлтийн дагуу ЭЗБШӨЧ төслөөс Хэвлэлийн хүрээлэн, Татварын ерөнхий газартай (ТЕГ) хамтран санхүүжүүлсэн хоёр өдрийн сургалт Эрдэнэт хотноо 2009 оны 4 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд боллоо. Сургалтад оролцсон 8 сонин, 6 телевиз, 2 радиогийн /үүний дотор Монголын Радио/ нийт 22 сэтгүүлчид тус улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 гаруй хувийг бүрдүүлж ирсэн Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрт (УБЭУ) зочилсон юм.



Эрдэнэт хотноо болсон дээрх сургалтын зорилго нь 1970-аад онд байгуулагдаж Монгол улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын (ААНОАТ) дийлэнх хэсгийг дангаараа бүрдүүлж ирсэн Эрдэнэт үйлдвэрийн борлуулалтын орлого, үйл ажиллагаа, улмаар улсын төсөвт дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямрал, бараа бүтээгдэхүүний үнийн

огцом бууралт хэрхэн нөлөөлж буй талаар сэтгүүлчдийг газар дээр нь бодит мэдээллээр хангахад оршиж байв.

Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрт зочилсон эхний өдөр тус үйлдвэрийн орлогч захирал н. Баярсайхан, Маркетинг хариуцсан захирал Д. Галбаатар нар сэтгүүлчдийг үйлдвэрийн захиргааны байрандаа хүлээн авч уулзсан бөгөөд дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямрал, зэсийн үнийн уналт нь тус үйлдвэрийн борлуулалтын орлого, ашиг, ААНОАТ төлөлтөд хэрхэн нөлөөлж байгааг дэлгэрэнгүй танилцууллаа. УБЭҮ нь 2008 онд улсын төсөвт 890 тэрбум төгрөг төлжээ. 2008 онд уул уурхайн олборлох салбарын 280 уурхай орлогын албан татвар төлсний 98 хувийг нь Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр дангаараа төлсөн нь ДНБ-ий 12.3 хувь, нийт экспортын 43 хувийг бүрдүүлсэн байна. Гэхдээ 2008 оны сүүлчээс дэлхийн зах зээлд зэсийн үнэ унаж, тус үйлдвэрийн борлуулалтын орлого эрс буурсантай холбоотойгоор тус үйлдвэрийн ашиг, улсын төсөвт төлөх орлогын албан татварын хэмжээ ихээхэн багассан учраас 2009 оны 1-3 сард орлогын албан татвар төлөхөд бэрхшээл тулгарч байна.

Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Маркетинг хариуцсан захирал Д. Галбаатар тус үйлдвэр байгуулагдсан цагаасаа хойш улсын төсөвт оруулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 70 орчим хувийг бүрдүүлж байсан тухай дэлгэрэнгүй мэдээлэв. Гэхдээ дэлхийн зах зээл дэх бүтээгдэхүүний үнийн уналтаас шалтгаалж борлуулалтын орлого буурч байгаа нь үйлдвэрээ цаашид хөгжүүлэх, өргөжүүлэх, зэс боловсруулах шинэ үйлдвэр байгуулж илүү их нэмүү өртөг бий болгох боломжид хүндрэл учруулж байгаа тухай ярилаа. Уулзалтын дараа сэтгүүлчдэд УБЭҮ-ийн Санхүүгийн хэлтсийн удирдах ажилтнуудаас асуулт асуух, ярилцлага авах боломж олдсон билээ. Сургалтад оролцогчид энэхүү уулзалт ярилцлагын дараа уурхайд очиж, тэсрэх материал ашиглан зэс, молибдений хүдэр олборлож байгаа байдалтай газар дээр нь танилцаж үйлдвэрлэлийн байранд зочлов.

Эрдэнэт хотноо зохион байгуулсан сургалтын хоёрдох өдөр Орхон аймгийн Татварын албаны дарга Ж. Эрдэнэбилэг, ТЕГ-ын шинээр байгуулагдсан Татвар төлөгчтэй харилцах харилцааны хэлтсийн дарга Д. Баяраа, мөн газрын Татвар хураалтын хэлтсийн дарга О. Энхсайхан, Олон нийттэй харилцах харилцааны хэлтсийн ажилтан Ц. Цэндсүрэн нар сэтгүүлчдэд зориулж Орхон аймгийн татварын хэлтсийн байранд нэг өдрийн сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтын үеэр татварын албаны удирдах ажилтнуудаас татвартай холбоотой асуулт асуух, ярилцах боломж сэтгүүлчдэд олдсон юм. УБЭҮ нь өнгөрсөн хугацаанд тус аймгийн татварын орлогын 97 орчим хувийг бүрдүүлж иржээ.

Эрдэнэт хотод болсон сургалтад оролцсон сэтгүүлчдийн зүгээс тус аймгийн татварын алба болон УБЭҮ-ийн удирдах ажилтнуудтай хийсэн ярилцлага нь асуудлыг ойлгоход ихээхэн ач холбогдолтой байсныг онцлон тэмдэглэжээ. Сургалтад оролцогчид мөн тус улсын эдийн засагт "Эрдэнэт үйлдвэр онцгой ач холбогдолтой болох талаар илүү их мэдээлэл өгсөн "энэхүү аялал нь татварын талаархи бидний мэдлэгийг сайжруулж, нүд нээж өглөө" гэж тайлагнасан байна.

Энэ 4 дүгээр сарын 8-ны өдөр болсон сургалтад оролцож, дараа нь Эрдэнэт хотод зочилсон 9 телевиз, 13 сонин, 2 радио, 3 сэтгүүлийн газар, МОНЦАМЭ агентлаг нь татвартай холбоотой асуудлуудаар мэдээ, өгүүлэл, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд татварын талаар мэдээлэл түгээхэд ТЕГ-т тусалцаа үзүүлсэн төдийгүй Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдал, тулгарч буй хүндрэлтэй асуудлууд, мөн дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямрал, татвар

бүрдүүлэлт, улсын төсвийн уялдаа холбооны талаархи олон нийтийн ойлголтыг сайжруулахад зохих хувь нэмэр оруулсан юм. Хэвлэлийн хүрээлэн нь цаашдаа татвартай холбоотой асуудлуудаар материал бэлтгэхэд сэтгүүлчидтэй хамтран ажиллаж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гарч буй татвартай холбоотой мэдээллийн чанарт цаашид мониторинг хийхээр болсон байна.

Төрийн байгууллагуудын вэбмастеруудад зориулсан сургалт боллоо

2009 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр 3 яам, 21 төрийн байгууллагын 24 вэбмастеруудыг оролцуулсан *Жуумла!* Агуулгын удирдлагын системийн (АУС) нэг өдрийн сургалт Мэдээлэл технологийн үндэсний паркт боллоо. Уг сургалтын онцлог нь вэбсайтын удирдлага, эх хэлнээ хөрвүүлсэн Unicode-ын дэмжлэгийг сайжруулах боломжийг ашиглахын тулд одоогийн ашиглаж буй *Жуумла! Монгол* хувилбарыг хамгийн сүүлд гарсан *Жуумла! АУС 1.5.10* хувилбартай харьцуулж, уг хувилбарт шилжих ач холбогдлыг оролцогчдод таниулж, дэмжлэг авахад оршиж байв.



Жуумла! Монгол хувилбарыг 2007 оны 12 дугаар сард нэвтрүүлснээс хойшхи хугацаанд төрийн 200 гаруй байгууллагын вэбсайт gov.mn домаянд бүртгэгдэж, Програм хангамжийн олон нийтийн эх лицензийн хүрээнд АУС-ийг ашиглаж байна. *Жуумла! АУС-ийн* Монгол хэлнээ бүрэн хөрвүүлсэн АУС-тэй болох нь төрийн байгууллагуудаас олон нийтийг мэдээллээр хангадаг вэбсайтуудаа зохих ёсоор ажиллуулах, боловсронгуй болгох боломжийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.